

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/72/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

53129 Өмнөд, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (978) 7043-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.НУРШАШХАН ТАНАА**

2022.02.25 № 213  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,038,225.00</u></b>	<b><u>13,518,670.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	600,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	600,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,438,225.00	13,518,670.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,918,225.00	12,998,670.00
35420	Аж ахуйн материал	5,853,199.00	6,949,899.00
35440	Түлш, шатах тослох материал	1,092,016.00	215,240.00
35460	Хүнсний материал	4,973,010.00	3,852,731.00
35470	Бусад хангамжийн материал	-	1,980,800.00
35600	Мал амьтад	520,000.00	520,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>140,556,069.92</u></b>	<b><u>133,753,465.10</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	140,556,069.92	133,753,465.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	138,156,069.92	131,353,465.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	129,058,532.23	129,058,532.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,697,356.32)	(12,976,909.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,852,526.00	25,502,526.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,399,963.03)	(22,154,450.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,480,774.00	21,480,774.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,160,162.88)	(17,799,565.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,155,040.00	10,155,040.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,005,040.08)	(5,030,040.12)
39217	Ном	2,871,720.00	3,117,558.27
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,400,000.00	2,400,000.00
39301	Програм хангамж	206,256.00	206,256.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(206,256.00)	(206,256.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,400,000.00	2,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>153,594,294.92</u></b>	<b><u>147,272,135.10</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>153,594,294.92</u></b>	<b><u>147,272,135.10</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	153,594,294.92	147,272,135.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,817,898.00	17,817,898.00
51101	Өмч: - төрийн	17,817,898.00	17,817,898.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	122,416,660.00	116,094,500.18
51210	Өмнөх үеийн үр дүн	122,416,660.00	122,416,660.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(6,322,159.82)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,359,736.92	13,359,736.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>153,594,294.92</u></b>	<b><u>147,272,135.10</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>241,230,333.00</b>	<b>222,849,247.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,332,376.00</b>	<b>245,838.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,332,376.00	245,838.27
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,332,376.00	245,838.27
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,332,376.00	245,838.27
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>237,897,957.00</b>	<b>222,603,409.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	226,228,800.00	211,709,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	226,228,800.00	211,709,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,488,909.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,488,909.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	11,669,157.00	6,405,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,669,157.00	6,405,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>248,647,339.67</b>	<b>229,171,407.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>248,647,339.67</b>	<b>229,171,407.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	233,303,539.27	221,073,907.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	164,944,292.00	162,583,300.00
210101	Үндсэн цалин	159,262,304.00	148,882,300.00
210104	Урамшуулал	5,681,988.00	9,163,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,537,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,299,495.69	21,867,900.00
210201	Тэтгэврийн даатгал	13,150,795.69	15,388,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,537,200.00	1,619,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,229,400.00	1,295,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	307,800.00	324,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,074,300.00	3,239,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,024,622.00	7,320,389.99
210301	Гэрэл, цахилгаан	1,244,622.00	1,093,100.00
210302	Түлш, халаалт	8,030,000.00	5,227,289.99
210303	Цэвэр, бохир ус	2,750,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,176,887.00	2,040,186.01
210401	Бичиг хэрэг	241,450.00	90,100.00
210402	Тээвэр, шатахуун	583,100.00	692,086.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	569,000.00	708,500.00
210404	Ном, хэвлэл	35,000.00	128,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	748,337.00	420,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,339,389.60	16,934,879.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,000.00	88,100.00
210502	Хоол, хүнс	6,133,789.60	16,279,279.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,139,600.00	567,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	548,000.00	-
210604	Урсгал засвар	548,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	103,000.00
210702	Дотоод албан томилолт	-	103,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	449,500.00	464,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	64,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	449,500.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,521,352.98	9,759,952.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,244,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,019,700.00	817,309.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,501,652.98	7,698,443.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,343,800.40	8,097,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,286,600.40	8,097,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,286,600.40	8,097,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	13,057,200.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,057,200.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(7,417,006.67)</u></b>	<b><u>(6,322,159.82)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(7,417,006.67)</u></b>	<b><u>(6,322,159.82)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,817,898.00	13,359,736.92	122,416,660.00	153,594,294.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,817,898.00	13,359,736.92	122,416,660.00	153,594,294.92
D08	Тайлант үеийн үр дүн			(6,322,159.82)	(6,322,159.82)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,817,898.00	13,359,736.92	116,094,500.18	147,272,135.10

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>237,897,957.00</u></b>	<b><u>222,603,409.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>237,897,957.00</u></b>	<b><u>222,603,409.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	226,228,800.00	211,709,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	226,228,800.00	211,709,500.00

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,488,909.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,488,909.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	11,669,157.00	6,405,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,669,157.00	6,405,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>237,897,957.00</b>	<b>221,953,409.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>237,897,957.00</b>	<b>221,953,409.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222,147,257.00</b>	<b>213,855,909.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	163,368,560.00	161,983,300.00
210101	Үндсэн цалин	144,866,531.00	148,282,300.00
210104	Урамшуулал	13,964,229.00	9,163,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	4,537,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,752,200.00	21,867,900.00
210201	Тэтгэврийн даатгал	14,603,500.00	15,388,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,537,200.00	1,619,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,229,400.00	1,295,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	307,800.00	324,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,074,300.00	3,239,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,669,157.00	6,405,000.00
210301	Гэрэл, цахилгаан	816,157.00	1,093,000.00
210302	Түлш, халаалт	8,103,000.00	4,312,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,750,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,096,540.00	2,078,300.00
210401	Бичиг хэрэг	241,450.00	90,100.00
210402	Тээвэр, шатахуун	583,100.00	730,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	569,000.00	708,500.00
210404	Ном, хэвлэл	134,090.00	128,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	568,900.00	420,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,791,600.00	15,943,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,000.00	88,100.00
210502	Хоол, хүнс	9,849,900.00	15,288,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,875,700.00	567,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	103,000.00
210702	Дотоод албан томилолт	-	103,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	449,500.00	528,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	128,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	449,500.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,019,700.00	4,945,909.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,830,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,019,700.00	1,115,909.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,750,700.00</b>	<b>8,097,500.00</b>

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,693,500.00	8,097,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,693,500.00	8,097,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,057,200.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,057,200.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<b>650,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<b>650,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<b>650,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	650,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		650,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<b>(650,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,114,500.00	218,114,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,114,500.00	218,114,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,017,000.00	210,017,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,983,300.00	161,983,300.00
210101	Үндсэн цалин	148,282,300.00	148,282,300.00
210104	Урамшуулал	9,163,200.00	9,163,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	4,537,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,867,900.00	21,867,900.00
210201	Тэтгэврийн даатгал	15,388,500.00	15,388,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,619,900.00	1,619,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,295,900.00	1,295,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	324,000.00	324,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,239,600.00	3,239,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,405,000.00	6,405,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,093,000.00	1,093,000.00
210302	Түлш, халаалт	4,312,000.00	4,312,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,078,300.00	2,078,300.00
210401	Бичиг хэрэг	90,100.00	90,100.00
210402	Тээвэр, шатахуун	730,200.00	730,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	708,500.00	708,500.00
210404	Ном, хэвлэл	128,700.00	128,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	420,800.00	420,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,943,800.00	15,943,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,100.00	88,100.00
210502	Хоол, хүнс	15,288,200.00	15,288,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	567,500.00	567,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	103,000.00	103,000.00
210702	Дотоод албан томилолт	103,000.00	103,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	528,700.00	528,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,700.00	128,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,107,000.00	1,107,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,107,000.00	1,107,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,097,500.00	8,097,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,097,500.00	8,097,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,097,500.00	8,097,500.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	218,114,500.00	218,114,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	211,709,500.00	211,709,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	211,709,500.00	211,709,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	6,405,000.00	6,405,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	6,405,000.00	6,405,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16.00	16.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	35.00	35.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	35.00	35.00
630001	Төрийн өмчит ЕБС	35.00	35.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>16.00</b>	<b>16.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>4,488,909.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>4,488,909.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	4,488,909.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	4,488,909.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,480,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,909.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд үйл ажиллаганы зорилго нь: Сурагчдыг бие даан бүтээлчээр сурах, хөгжих, хүмүүжих сургалтын таатай орчинг бүрдүүлэн “Зөв монгол хүн” болгон төлөвшүүлэх

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

1. Хүүхэд бүрийн авъяас, сонирхлыг хөгжүүлж, зөв хүн төлөвшүүлэх.
2. Сургалтын үйл ажиллагаанд чанарын ахиц тооцон, сурагчдын хэрэгцээ, сурах үйл, оролцоог дэмжинэ.
3. Хүүхдэд ээлтэй сургалтын эрүүл, аюулгүй, таатай орчин бүрдүүлэх.
4. Эмх цэгц, дэг журам, ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлыг чанд сахих.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд бусад байгууллагуудас ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 248.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	600.0	-	(600.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	12,438.2	13,518.7	1,080.4
Үндсэн хөрөнгө	140,556.1	133,753.5	(6,802.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>153,594.3</b>	<b>147,272.1</b>	<b>(6,322.2)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	153,594.3	147,272.1	(6,322.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>153,594.3</b>	<b>147,272.1</b>	<b>(6,322.2)</b>

Мөнгөн хөрөнгө, авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13.5 сая төгрөг болж 1.1 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 32.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 31.5 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 6.8 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 0.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газраас 0.2 сая төгрөгийн номыг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөнд 7.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхэн ба эцэст өглөггүй гарсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 147.3 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 6.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсвийг 215.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 218.1 сая төгрөг болгон 2.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшлыг 13.2 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 13.4 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 0.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилтээс 211.7 сая, орон нутгийн төсвөөс 6.4 сая бүгд төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд 218.1 сая төгрөг зарцуулж төсөвтөө багтаан ажилласан байна.

Төсвийн нийт зарлагын 84.3 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 15.7 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дэлхийн банкны санхүүжилтээр Боловсрол шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинчлэл төслийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 шат” -д шалгарсан төслөөс 4.5 сая төгрөг оруулсаныг байгууллагын нэмэлт дансаар хүлээн авч, 4.5 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардал, НДШ-ийн зардал, халаалтын зардал, хоолны зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зэрэг зардалд нийтдээ 211.6 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зарлагаас үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.5 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.6 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа боловч төмвийг хэмнэх арга хэмжээ авч ажиллаагүй

Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд нийт 222.6 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 154.9 сая төгрөгийн 113 мэдээллийг хугацаанд мэдээлсэн, 4 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа болоогүй 2 мэдээлэлийг байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 56.8 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж 77.8 хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар 2 заалт бүхий зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **66,5** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66,6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

##### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

##### 4.2 Төлбөрийн акт

Акт тогтоогоогүй

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 66,5 сая төгрөгийн зөрчилд зөрчил аригуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр 218.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бусад 6.5 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 0.6 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1, -д “*Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай*”, 1.1-д “*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 56.8 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээний мэдээллийг оруулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 77.8 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*”, 6.1.2-т “*хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор*”; 6.4.4-д “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, 6.4.8-д “*өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3.Бараа материалын дансны эхний, эцсийн үлдэгдлийг нярвын материалын тайлангийн эхний үлдэгдэлтэй тулган шалгахад хүнсний материалын эхний үлдэгдлийг 0.4 сая мянган төгрөгөөр дутуу, түлш, шатах тослох материалын эхний үлдэгдлийг 0.6 сая мянган төгрөгөөр, хүнсний материалын эцсийн үлдэгдлийг 0,8 сая төгрөгөөр, түлш, шатах тослох материалын эцсийн үлдэгдлийг 1,1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Харилцах данснаас хоолны зардал, түлш, шатах материалд шилжүүлсэн зарлагын гүйлгээг нярвын бараа материалын тайлангийн орлоготой тулгаж үзэхэд хүнсний материалын орлогыг 3.6 сая төгрөгөөр, түлш, шатах тослох материалын орлогыг 1.1 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан. Аж ахуйн материалын тайлангийн анхан шатны баримтын хөтлөлт, бүрдүүлэлт хангалтгүй.

Санхүүгийн тайланд олон жил он дамжсан 0.5 сая төгрөгийн мал бүртгэлтэй байгаа боловч бодитоор байхгүй, шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, Ковид-19 цар тахлын хязгаарлалтын үед Тавалтайн постод ажилласан ажилчдын хоол хүнсэнд олгосон 0.8 сая төгрөгийн хүнсний материалыг зарцуулах талаар, захирамж, тушаал шийдвэрийг бүрдүүлж баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д *"Үнэн зөв байх"*, 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.5-т *"Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..."*, 13.7-т *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 14 дүгээр зүйлийн 14.3-д *"Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ"*, 14.3.1-д *"анхан шатны баримт бүрдүүлэх"*, 14.4-д *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4-д *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.1 *"аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын ЕБ-ын 3-р сургууль	3	66,5					3	66,5		